



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Гавшгай ус ААТҮГ-ын 2021 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2022/07/НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040

Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036

Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Пийк ОМ Аудит ХХК

Утас: 99862066

Цахим хаяг: [peakomaudit@gmail.com](mailto:peakomaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	11
4. Аудитын тайлан .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Дотоод хяналт .....	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
4.4 Материаллаг байдал .....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	14
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
8. Аудитын илрүүлэлт .....	16
8.1 Залруулсан алдаа .....	16
8.2 Албан шаардлага .....	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн Газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨБАҮ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЗА 2022/07-НА-СТА-ОНА

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Гавшгай Ус” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Гавшгай Ус” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

СЗА-2022/07-НА-СТА-ОНА

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
1	<b>ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,663,247.25	58,623,347.57
1.1.2	Дансны авлага	1,544,250,548.78	1,315,207,379.54
1.1.6	Бараа материал	295,464,211.40	275,013,668.86
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,800,000.00	2,800,000.00
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	1,845,178,007.43	1,651,644,395.97
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,779,181,220.10	6,471,666,919.10
1.2.2	Биет бус хөрөнгө	838,551,196.00	849,672,196.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	7,617,732,416.10	7,321,339,115.10
1.3	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	9,462,910,423.53	8,972,983,511.07
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	0.00	0.00
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	0.00	0.00
2.1.1	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	253,530,589.28	226,093,297.16
2.1.1.2	Цалингийн өглөг	84,405,364.93	79,463,649.81
2.1.1.3	Татварын өр	642,792,344.40	524,489,725.74
2.1.1.4	НДШ - ийн өглөг	987,535,948.29	901,054,450.10
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	1,951,200.00	1,951,200.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	1,970,215,446.90	1,733,052,322.81
2.1.2	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	0.00
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	0.00	0.00
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	1,970,215,446.90	1,733,052,322.81
2.3	<b>Өмч</b>	294,374,941.69	294,374,941.69
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,296,382,891.35	7,296,382,891.35
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,556,423,439.00	1,556,423,439.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,654,486,295.41)	(1,907,250,083.78)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	7,492,694,976.63	7,239,931,188.26
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	9,462,910,423.53	8,972,983,511.07

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,542,491,724.00	1,426,804,303.00
2	Борлуулалтын өртөг	1,789,347,347.60	1,580,141,595.84
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>-246,855,623.60</b>	<b>-153,337,292.84</b>
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	6,286,656.07	14,405,001.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	185,640,864.31	60,321,803.29
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	39,182,479.38	53,509,693.24
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	0.00	0.00
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-465,392,311.22</b>	<b>-252,763,788.37</b>
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-465,392,311.22</b>	<b>-252,763,788.37</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>-465,392,311.22</b>	<b>-252,763,788.37</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	<b>2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	-1,189,093,984.19	7,958,087,287.85
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	-1,189,093,984.19	7,958,087,287.85
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-465,392,311.22	-465,392,311.22
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	<b>2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	-1,654,486,295.41	7,492,694,976.63
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	-1,654,486,295.41	7,492,694,976.63
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-252,763,788.37	-252,763,788.37
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	<b>2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	-1,907,250,083.78	7,239,931,188.26

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	811,770,258.72	1,411,796,004.40
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	811,770,258.72	1,411,796,004.40
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	824,007,153.19	1,321,484,904.08
1.2.1	Ажиллагчдад төлсөн	503,223,651.00	522,720,695.08
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	53,849,154.00	256,493,642.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	25,610,920.96	157,721,598.45
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	37,348,352.44	31,242,531.69
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	53,493,364.04	73,894,395.22
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	4,444,106.68
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	122,599,739.48	253,455,555.89
1.2.9	Бусад мөнгөн зарлага	27,881,971.27	21,512,379.07
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-12,236,894.47	90,311,100.32
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	0.00	0.00
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	0.00	34,351,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	23,230,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	11,121,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	0.00	-34,351,000.00
3	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.00	0.00
3.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>14,842,000.00</b>	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	14,842,000.00	0.00
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>9,137,719.52</b>	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	9,137,719.52	0.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	5,704,280.48	0.00
4.1	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-6,532,613.99	55,960,100.32
5	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	9,195,861.24	2,663,247.25
6	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	2,663,247.25	58,623,347.57

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
	<b>Орлогын нийт дүн</b>	<b>1,266,222.80</b>	<b>1,441,209.30</b>	<b>(174,986.50)</b>	<b>113.82</b>
1.1	Цэвэр бохир ус	621,102.80	630,512.10	(9,409.30)	101.51
1.2	Бохир усны борлуулалт	309,081.40	411,339.00	(102,257.60)	133.08
1.3	Дулаан эрчим хүч	138,121.80	153,486.20	(15,364.40)	111.12
1.5	Суурь хураамж	50,049.30	53,555.20	(3,505.90)	107.00
1.6	Шугам ашиглалт	140,850.00	176,919.50	(36,069.50)	125.61
1.7	Үйл ажиллагааны бус орлого	7,017.50	15,397.30	(8,379.80)	219.41
	<b>Нийт зардлын дүн</b>	<b>1,889,673.90</b>	<b>1,693,973.10</b>	<b>195,700.80</b>	<b>89.64</b>
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	646,559.80	633,071.10	13,488.70	97.91
2	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	90,518.40	91,795.30	(1,276.90)	101.41
3	Цахилгаан өөрийн хэрэглээ	320,659.20	277,875.90	42,783.30	86.66
4	Дулаан- өөрийн хэрэглээ	18,387.00	20,405.50	(2,018.50)	110.98
5	Нүүрс	63,877.90	65,747.40	(1,869.50)	102.93
6	Түлш, шатахуун, тээврийн зардал	44,587.90	40,007.80	4,580.10	89.73
7	Харуул хамгаалалтын зардал	43,678.20	-	43,678.20	-
8	Засвар, үйлчилгээний зардал	131,647.60	117,075.20	14,572.40	88.93
9	Ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	7,978.30	4,298.80	3,679.50	53.88
10	Бичиг хэрэг, томилот	4,054.90	2,591.00	1,463.90	63.90
11	Хөдөлмөр хамгааллын зардал	23,980.10	27,800.00	(3,819.90)	115.93
12	Маркетинг, борлуулалтын зардал	5,331.00	1,029.10	4,301.90	19.30
13	Лаборатори, шинжилгээний зардал	3,160.00	1,462.40	1,697.60	46.28
14	Гүйцэтгэх удирдлагын зардал	18,089.10	10,940.40	7,148.70	60.48
15	ТУЗ-ын зардал	16,000.00	300.10	15,699.90	1.88
16	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	357,979.80	330,744.30	27,235.50	92.39
17	Халаалтын буцаалт		-	-	-
18	Зохицуулалт үйлчилгээний хөлс	6,000.00	800.00	5,200.00	13.33
19	Гадны үйлчилгээний хөлс	10,190.40	20,601.30	(10,410.90)	202.16
20	Татварын зардал	5,451.20	1,769.80	3,681.40	32.47
21	Даатгалын зардал	4,500.00	-	4,500.00	-
22	Үйл ажиллагааны бусад зардал	37,398.10	28,003.60	9,394.50	74.88
23	Ажиллагсдын нийгмийн зардал	29,645.00	17,654.10	11,990.90	59.55
<b>24</b>	<b>Ашиг, алдагдал</b>	<b>(623,451.10)</b>	<b>(252,763.80)</b>	<b>(370,687.30)</b>	<b>40.54</b>

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Гавшгай ус” ААТҮГ нь “Цэвэр усыг танд Цэнгээг усыг байгальд ” зорилтын доор иргэд, аж ахуйн нэгж төр төсвийн байгууллагуудад цэвэр усыг нийлүүлж, бохирыг усыг татан зайлуулах ажиллагааг 24 цагийн турш тасралтгүй гүйцэтгэж орлогын эх үүсвэрээ найдвартай ханган ажиллаж байна” гэсэн зорилго дэвшүүлсэн байна.

“Гавшгай ус” ААТҮГ-ын дүрэмд тус газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сайхан сум, Номгон тосгоны айл өрх, албан байгууллагыг унд, ахуйн цэвэр усаар хангах, ахуйн болон үйлдвэрийн бохир шингэнийг татан зайлуулах,
- Номгон тосгоныг дулаанаар хангах,
- Орон сууцны барилгын сантехникийн систем, тоног төхөөрөмж, шугам хоолойн ашиглалтын засвар үйлчилгээг гүйцэтгэх .

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэж бүртгэгдсэн бөгөөд 100 хувь орон нутгийн өмч эзэмшиж байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Гавшгай Ус” ААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Гавшгай ус” ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 80 дугаар тогтоолоор “Гавшгай ус” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-д “ Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, 19 дүгээр зүйл “Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх “**Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс

шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 тоот тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Айл өрхийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж”-ийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх,
- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам”, “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ууд гэх мэт.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Гавшгай Ус ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 489,926.9 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,663.2	58,623.3	55,960.1
Авлага	1,544,250.6	1,315,207.4	(229,043.2)
Бараа материал	295,464.2	275,013.7	(20,450.5)
Урьдчилж төлсөн зардал	2,800.0	2,800.0	-
Үндсэн хөрөнгө	7,617,732.4	7,321,339.1	(296,393.3)
Нийт хөрөнгө	9,462,910.4	8,972,983.5	(489,926.9)
Богино хугацаат өр төлбөр	1,970,215.4	1,733,052.3	(237,163.1)
Урт хугацаат өр төлбөр	-	-	-
Эздийн өмчийн дүн	7,492,695.0	7,239,931.2	(252,763.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,462,910.4	8,972,983.5	(489,926.9)

Байгууллагын касс 67.1 мянган төгрөг, банкин дахь харилцах дансанд 58,556.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж, өмнөх оноос мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт 58,623.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд касс болон харилцахаар 1,985,837.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,929,877.2 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 1,315,207.4 мянган төгрөг болж 229,043.2 мянган төгрөгөөр буурсан нь оршин суугчдаас авах усны авлага 288,194.0 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалжээ.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 275,013.7 мянган төгрөг болж өмнөх оноос 20,450.5 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 107,205.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 127,655,9 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс /анхны өртгөөр/ 8,533,308.9 мянган төгрөг болж 34,351.0 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 19,800.0 мянган төгрөгийн 1 ширхэг уурын тогоо, 11,121.0 мянган төгрөгөөр Diamond санхүүгийн программ, 1,890.0 мянган төгрөгөөр 2 ширхэг хувцасны шкаф, 2 ширхэг төмөр сандал тус тус худалдан авч, 1,540.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бараа солилцоогоор бүртгэж авснаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр 237,163.1 мянган төгрөгөөр буурсан нь нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 122,390.5 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 86,781.5 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 7,239,931.2 мянган төгрөг болж, 252,763.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

#### **3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Гавшгай Ус ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Гавшгай Ус” ААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан бөгөөд тайлант оны орлогыг 1,266,222.8 мянган төгрөгөөр, зардлыг 1,889,673.9 мянга төгрөгөөр баталж, 623,451.1 мянган төгрөгийн алдагдал хүлээхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,441,209.3 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, 1,693,937.1 мянган төгрөгийн зардал гаргаж, 252,763.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 1,441,209.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 174,886.5 мянган төгрөг буюу 13.8 хувиар давж биелсэн нь бохир усны борлуулалтыг бодитоор төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,693,937.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 195,736.8 мянган төгрөг буюу 10.4 хувиар хэмнэгдсэн нь харуул хамгаалалтын болон цахилгааны зардал хэмнэгдсэнээс голлон нөлөөлсөн байна.

Тайлант оны алдагдал төлөвлөснөөс 350,687.4 мянган төгрөгөөр бага буюу 252,763.7 мянган төгрөг болсон байна.

## 4. Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын “Гавшгай Ус” ААТҮГ-ын / цаашид Гавшгай Ус ААТҮГ гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардлын бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмж тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Пийк ОМ Аудит ХХК-ийн аудитор А. Батболд, аудиторын туслах А.Оюун-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар хэрэгжүүлсэн.

“Гавшгай Ус” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Пийк ОМ Аудит ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Дотоод хяналт

Газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд үйлдвэрийн газрын өөрийн дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн байна.

Тайлант хугацаанд аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт болох аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Гавшгай Ус ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,693,973.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,939.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 11,857.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, -6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Гавшгай Ус” ААТҮГ нь тайлант онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 40 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 99 мэдээллийг хугацаа хоцроон, 10 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**Шийдвэрлэсэн нь:** Мэдээллийг тогтоосон хугацаанд нь шилэн дансанд мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

#### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц,

чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасныг зөрчин байгууллагын 90 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан 737.0 мянган төгрөгийг, шинэ жилийн баяраар 2,260.0 мянган төгрөгийг шагнал, урамшуулал, бэлэг дурсгалд зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## 6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгснөөс албан шаардлага, зөвлөмж 57.1 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	67,811.5	3	67,811.5	1		75
Зөвлөмж	3		1		2		33.3
Нийт дүн	7	67,811.5	4	67,811.5	3		42.8

Өмнөх аудитаар өгсөн худалдан авалтын анхан шатны зарим баримтууд нь төлбөрийн цахим системд шивэгдээгүй, санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь ил тод, бүрэн мэдээлээгүй зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлэлгүйгээр давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

**7.1** Тус газар нь НДШ, ХХОАТ-ын их хэмжээний өр төлбөртэйн улмаас орлогын дийлэнхийг касст бэлнээр төвлөрүүлэн, мөнгөн гүйлгээний нийт зардлын 51 хувьтай тэнцэх 690,353.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэж байгаа нь хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна.

**7.2** 2020 онд санхүүгийн программын урьдчилгаа төлбөр болох 2,800.0 мянган төгрөгийг урьдчилан төлж, урьдчилж гарсан зардлаар тайлагнан уг программыг тодорхой хугацаанд ашиглаж байгаад үлдэгдэл төлбөрийг төлөлгүйгээр 2021 онд Diamond санхүүгийн программыг худалдан авч бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

Цаашид урьдчилж гарсан зардлаар тайлагнагдсан 2,800.0 мянган төгрөгийн программын үр дүнг үнэлж, холбогдох бичилтүүдийг хийж гүйцэтгэх нь зүйтэй юм.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 126,235.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 34,351.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1,290.1 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс 70,794.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлж, 19,800.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

### 8.1 Залруулсан алдаа

Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн 34,351.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тусгасан байсныг залруулав.

Залруулагдаагүй буюу материаллаг алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### 8.2 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайланд өглөг үүсгэлгүйгээр захирлын 2020 оны 55 дугаар тушаалыг үндэслэн Ц.Цэнддоржид 1,290.1 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно”, 14 дүгээр зүйлийн 14.4. дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3.бүх өр төлбөр” гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- Санхүүгийн тайлан гаргахын өмнө татвар, нийгмийн даатгалын байгууллагуудтай өглөг, авлагын тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 70,794.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана*” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр давтан гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

### **8.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хөрөнгийн худалдан авалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 19,800.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн жилийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Гавшгай Ус ААТҮГ	СЭА-2022/07/НА-СТА-ОНА	Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө худалдан авсан мөнгөн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тусгасан.	Аудитын явцад залруулсан	1	34,351.0	1	34,351.0								
2	Гавшгай Ус ААТҮГ	СЭА-2022/07/НА-СТА-ОНА	Захирлын 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 55 тоот тушаалыг үндэслэн тэтгэмж олгосон	Албан шаардлага хүргүүлсэн	1	1,290.1					1	1,290.1				
3	Гавшгай Ус ААТҮГ	СЭА-2022/07/НА-СТА-ОНА	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан	Сахилгын шийтгэл ногдуулах	1	70,794.2							1	70,794.2		
4	Гавшгай Ус ААТҮГ	СЭА-2022/07/НА-СТА-ОНА	Төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан	Зөвлөмж	1	19,800.0									1	19,800.0
<b>ДҮН</b>					<b>4</b>	<b>126,235.3</b>	<b>1</b>	<b>34,351.0</b>			<b>1</b>	<b>1,290.1</b>	<b>1</b>	<b>70,794.2</b>	<b>1</b>	<b>19,800.0</b>
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Гавшгай Ус ААТҮГ	СЭА-2022/07/НА-СТА-ОНА	Захирлын 2021 оны 29, 30 дугаар тушаалуудаар шагнал, урамшуулал олгосон	Төлбөрийн акт тогтоох	1	2,997.0			1	2,997.0						
<b>ДҮН</b>					<b>1</b>	<b>2,997.0</b>			<b>1</b>	<b>2,997.0</b>						
<b>НИЙТ ДҮН</b>					<b>5</b>	<b>129,232.3</b>	<b>1</b>	<b>34,351.0</b>	<b>1</b>	<b>2,997.0</b>	<b>1</b>	<b>1,290.1</b>	<b>1</b>	<b>70,794.2</b>	<b>1</b>	<b>19,800.0</b>